

ХУДГИЙН АЖЛЫН ДААЛГАВАР, ТАВИГДАХ ШААРДЛАГА
/Увс аймаг, Тэс сум 2-р баг/

1. Худаг шинээр барихаас өмнөх ба дараа үеийн гэрэл зургийг нэг цэгээс авч, худгийн солбицлыг нарийвчлан тодорхойлсон байна.
2. Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага **MNS6088: 2010** стандартын дагуу өрөмдлөг, шавхалт, туршилтын ажлыг явуулах, худгийн усны шахуурга, цахилгаан үүсгүүрийг сонгох, худгийн барилга барих ажлыг гүйцэтгэнэ.
3. Монгол улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 101/189/194 тоот хамтарсан тушаалаар баталсан “Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах, нийтлэг журам”-ыг мөрдөнө. Үүнд:

Үзүүлэлтүүд	
1	Цооног өрөмдөх, цооногийг тоноглох
1.1	Шинээр баригдах багийн төвийн дэргэд сумын ЗДТГ-аас худгийн байршлыг заалгаж БОАЖГ-аас зөвшөөрөл авсан байна.
1.2	Цооногийн ашиглалтын ундарга: 0.6-2 л/сек ус өгөх хүчин чадалтай байна.
1.3	Суултын яндангийн материал нь ган хоолой байна.
1.4	Шүүрийн яндангийн материал нь ган хоолой байна.
1.5	Ус өргөх яндангийн диаметр 25 мм-ээс багагүй, материал нь төмөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой /хүйтний улиралд тэсвэртэй/
1.6	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 9мм-ээс томгүй байна.
1.7	Тунгаагуурын урт: 2м-ээс багагүй
1.8	Худгийг шавхалт хийж цэвэрлэх хугацаа: 48 цагаас багагүй
1.9	Усны чанарын сорилт авах шинжилгээ хийлгэх
1.10	Худгийг түр хугацааны тагаар тоноглох
2	Худгийн байшин, усан сан, мал услах онгоц, талбай барих
2.1	Худгийн байшингийн <ul style="list-style-type: none"> • Хэмжээ /дотор талдаа/: 3м х 3м, ханын өндөр шалнаас дээш 2 м • Материал: тоосго, блок • Ханын зузаан: 38 см-ээс багагүй. • Ханыг дотор талаас нь шавардаж, цагаан өнгөөр будна. • Худгийн дээр 30 см х 30 см хэмжээтэй нээлхийг тохируулан хийнэ. Нээлхийг худгийг засварлахад хэрэглэнэ. • Худгийн цонх нь 30см х 30 см хэмжээтэй, мал услах онгоцны чанх харалдаа байрлана. Хамгаалалтын төмөр сараалжин хаалттай байна. • Дундаа 5см-ийн хөөсөн дулаалгатай төмөр хаалгатай байна.
2.2	Мал услах онгоцонд ус өгөх хоолой нь: 60мм диаметртэй, гаднах ханаас 2м урттай гадагшилсан ган хоолойг цонхны доор гаргах

2.3	Ундны ус авах хоолой нь: 25; 32 мм диаметртэй, ган хоолойг цонхны доор гаргах /ундны ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгох/
2.4	40 мм-ийн диаметртэй цоорхойг генераторын утааг гадагшлуулах зорилгоор генераторын янданд яг тохируулан тохиромжтой байрлалд гаргана.
2.5	Босоо суурьтай тоноглогдсон, гагнаж хийсэн, дотор талыг зэврэлтээс хамгаалсан 1,5м ³ -ээс багагүй багтаамжтай ган усан сан, дээгүүрээ модон тагтай байна.
2.6	Мал услах онгоц: <ul style="list-style-type: none"> • Хэмжээ: 9м-ээс багагүй урттай, 400мм-ийн голчтой хагас цилиндр • Материал: ган хоолой буюу цутгамал төмөр бетон • Худгийн байшингаас 1-2 хэмийн налуутайгаар 2м-ийн зайд байрлуулна. • Онгоцны адагт үлдэгдэл ус юүлэх жижиг нээлхий гаргана. Нээлхийг онгоцонд ус өгөх үед эрэгдэж хаадаг байхаар хийнэ. • Усан сангаас мал услах онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ёроолын усыг бүрэн шавхахаар байрлуулж гагнана. Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг аюулгүй болгож засна.
2.7	Мал услах талбай: <ul style="list-style-type: none"> • Хэмжээ: нийт уртын дагуу 2 талдаа тус бүр 1м-ийн өргөнтэй, зузаан нь 10 см. • Материал: 150 маркаас доошгүй цемент хэрэглэнэ. Талбайг хийхдээ бетоныг төмөр тороор хүчитгэж өгнө. • Услах талбай нь худгийн байшин болон мал услах онгоцтой харьцуулахад бага зэрэг налуу байдалтай хийгдэх бөгөөд үлдэгдэл ус болон асгарсан ус юүлэхэд тохиромжтой байна.
3	Худгийн насос, бага оврын генератор, цахилгааны утас, хянах самбар
3.1	Гүний насос: ISO9001 стандартын шаардлага хангасан, Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх
3.2	Цахилгааны утас: 3 салаа, худагт ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн /залгаасгүй/, ус өргөх янданд 2 м тутамд хавчиж /туузаар ороож болохгүй/ тогтооно.
3.3	Хянах самбар: Асаах унтраах товчлууртай, насос ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан/ гэрлээр асаах индикатортой, насос ажиллуулах асаагууртай.
3.4	Бага оврын генератор: Бензинээр ажилладаг /ISO стандартын шаардлага хангасан/ Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх, техникийн үзүүлэлт, ашиглалтын зааварыг монгол хэлээр ирүүлнэ.
4	Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх
4.1	Талбайг цэвэрлэх /өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаягдал гэх мэт/
4.2	Худаг, гүний насос, жижиг оврын генераторыг ажиллуулах, үйлчилгээ хийх, талбайн сургалт хийх
4.3	Худгийн өрөмдлөг, цооногийн хийц, шавхалт, тоног төхөөрөмжийг суурилуулах ажлыг MNS6088:2010 стандартын дагуу гүйцэтгэж баримтжуулан, худгийн паспорт хөтөлсөн байна.